# САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 07 дугаар сарын 04 Арвайхээр

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа цаасан хэлбэрээр нийт 146 иргэнээс судалгаа авсан.

Тухайн байгууллага, аж ахуйн нэгжид хийгдсэн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хэр чанартай хэрэглэгчдэд хүртээмжтэй, үнэн зөв шударга хийгдсэн талаар асуулгад 78,8 хувь нь хангалттай сайн, 17,8 хувь нь дунд түвшинд, хяналт шалгалт, дотоод аудитын үр дүнг хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуулгад 60,3 хувь нь үр дүн маш сайн, 28,1 хувь нь үр дүн дунд түвшинд байна, өмнөх санхүүгийн хяналт шалгалтын үр дүнд танай байгуулагад ямар өөрчлөлт гарсан бэ? гэсэн асуулгад 22,6 хувь нь эерэг өөрчлөлтүүд маш их гарсан, 15,8 хувь нь өөрчлөлт огт гараагүй, 14,4 хувь нь илэрсэн санхүүгийн зөрчлүүд арилж байгаа, 39 хувь нь мэдэхгүй, танай байгууллагын дотоод хяналтын нэгж нь байгууллагынхаа санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж чадаж байгаа юу? гэсэн асуулгад 29,5 хувь нь огт хийхгүй байгаа, 44,5 хувь нь дунд түвшинд хийж байгаа, 16,4 хувь нь сайн хийгдэж байгаа, 8,9 хувь нь санхүүгийн мэдлэггүйгээс хийж чадахгүй байгаа, танай байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа ил тод нээлттэй байж чадаж байгаа юу? гэсэн асуулгад 34,9 хувь нь санхүүгийн бүх мэдээлэл ил тод байгаа, 18,5 хувь нь зарим мэдээллийг бидэнд мэдээлдэггүй, 41,8 хувь нь санхүүгийн үйл ажиллагааг ил тод болгож чадаагүй, Авлигаас ангид байж хяналт шалгалт нээлттэй, ил тод явагдаж чадсан уу гэсэн асуулгад 83,8 хувь нь тийм гэж тус тус хариулсан.

Судалгааны үр дүнгээс үзэхэд: Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд ил тод нээлттэй байдлаар явагдаж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, зөвлөгөө өгөх байдал, санхүүгийн хяналт шалгалтын үр дүн хангалттай, харилцаа хандлага сайн байгааг илэрхийлж байна. Үнэлгээгээр тухайн байгууллагуудын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, сайжруулах, хөгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Үнэлгээнд хамрагдсан хэрэглэгчдээс сургалт авах, хяналт шалгалтыг 1-2 жил тутамд тогтмол хийх, хяналт шалгалтыг ойр ойр хийснээр зөрчил дутагдал арилах, заавар зөвлөмжийг авч ажилласнаар санхүүгийн үйл ажиллагаа сайжирна гэсэн хүсэлтүүд ирүүлсэн.

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЛХАМДОЛГОР

ТАЙЛАН ГАРГАСАН:

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Д.ЧУЛУУНБАДРАХ

**Өвөрхангай аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2023 онд хяналт шалгалт хийгдсэн байгууллагуудаас авсан хэрэглэгчийн үнэлгээ**

ХЭРЭГЛЭГЧИЙН СУДАЛГАА-146

2023.07.04

| | Асуулга | | Сонголтууд | Арвайхээр | 5 дугаар сургууль | Нийгмийн даатгал | Баянгол сум | Өлзийт сум | Нийт | Хувиар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Энэ удаагийн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хэр үнэн шударга, бодитой хийгдсэн гэж та үзэж байна | А | Хангалт+D4:D21тай сайн хийгдсэн | 3 | 51 | 10 | 18 | 33 | 115 | 78.8 |
| | | Б | Дунд түвшинд хийгдсэн. Яагаад | 1 | 19 | 2 | 1 | 3 | 26 | 17.8 |
| | | В | Хангалтгүй муу хийгдсэн. Яагаад | | 1 | 1 | | | 2 | 1.4 |
| | | Г | Мэдэхгүй | | 1 | | | | 1 | 0.7 |
| 2 | Санхүүгийн хяналт шалгалтын үр дүнг та хэрхэн үнэлж байна вэ? | А | Хяналт шалгалтын үр дүн маш сайн байгаа | 3 | 29 | 9 | 15 | 32 | 88 | 60.3 |
| | | Б | Хяналт шалгалтын үр дүн дунд түвшинд байна | 1 | 31 | 2 | 4 | 3 | 41 | 28.1 |
| | | В | Хяналт шалгалтын үр дүн манай байгууллагад мэдрэгдэхгүй байна | | 8 | | | 1 | 9 | 6.2 |
| | | Г | Хяналт шалгалтын үр дүн муу байна | | 4 | 2 | | | 6 | 4.1 |
| 3 | Өмнөх санхүүгийн хяналт шалгалтын үр дүнд танай байгуулагад ямар өөрчлөлт гарсан бэ? Энэ нь танд хэрхэн нөлөөлсөн бэ? | А | Зэрэг өөрчлөлтүүд маш их гарсан | 4 | 11 | 5 | 5 | 8 | 33 | 22.6 |
| | | Б | Өөрчлөлт огт гараагүй | | 15 | | | 8 | 23 | 15.8 |
| | | В | Илэрсэн санхүүгийн зөрчлүүд арилж байгаа | | 3 | 2 | 7 | 9 | 21 | 14.4 |
| | | Г | Мэдэхгүй | | 37 | 4 | 7 | 9 | 57 | 39.0 |
| 4 | Танай байгууллагын дотоод хяналтын нэгж нь байгууллагынхаа санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж чадаж байгаа юу? | А | Огт хийхгүй байгаа | | 32 | 3 | | 8 | 43 | 29.5 |
| | | Б | Дунд түвшинд хийж байгаа | 3 | 29 | 5 | 7 | 21 | 65 | 44.5 |
| | | В | Сайн хийгдэж байгаа | 1 | 3 | 4 | 10 | 6 | 24 | 16.4 |
| | | Г | Санхүүгийн мэдлэггүйгээс хийж чадахгүй байгаа | | 11 | | 2 | | 13 | 8.9 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Танай байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа ил тод нээлттэй байж чадаж байгаа юу? | А | Санхүүгийн бүх мэдээлэл ил тод байгаа | 3 | 7 | 9 | 12 | 20 | 51 | 34.9 |
| | | Б | Зарим мэдээллийг бидэнд мэдээлдэггүй. Ямар төрлийн мэдээлэл: | Урьдчилан сэргийлэх ажил чанартай хийх | 12 | Үйл ажиллагааны зардал | 4 | 9 | 27 | 18.5 |
| | | В | Санхүүгийн үйл ажиллагааг ил тод болгож чадаагүй | | 51 | 1 | 1 | 8 | 61 | 41.8 |
| | | Г | Санхүүгийн мэдээллийг бид ойлгодоггүй | | 4 | | 2 | | 6 | 4.1 |
| 6 | Авлигаас ангид байж хяналт шалгалт нээлттэй, ил тод явагдаж чадсан уу | А | Тийм | | | 12 | 19 | 26 | 57 | 83.8 |
| | | Б | Үгүй. Яагаад | | | | | 4 | 4 | 5.9 |
| 7 | Санхүүгийн хяналт шалгалттай холбоотой таны санал | | | Зөвлөмж мэдээллээр сайн хангах | 1.Байгууллагад хяналт шалгалтыг үнэн зөвөөр хийж ил тод нээлттэй танилцуулсанд баярлалаа<br>2. Нягтлан бодогчийн байдлыг ил тод болгож дүн тооцоог танилцуулах, хариуцлага хүлээлгэх<br>3. Багш нарын илүү цагийг сар бүр тооцдоггүй сар дамжуулан тооцдог, зарим албан хаагч ажилтаны үйл ажиллагаа санхүүгийн холбоо хамаарлыг шалгах<br>4. Нэмэлт орлогын зарцуулалтыг ил тод мэдээллэж байх<br>5. Сургалт авах<br>6. Дахин дэлгэрэнгүй шалгалт хийх, шалгалт хийхдээ албан хаагчдаас асууж тодруулж байх | 1. Ямар нэгэн өөр өнцөгөөс харж энэ шалгалтыг хийсэн гэж үзэж байна.<br>2. Сайн хийгдэж байна. Ажилд нь амжилт хүсье.<br>3. Маш их баярлалаа, үр дүнтэй шалгалт байлаа. | 1. Жил бүр ирж шалгах<br>2. Ажлын өндөр амжилт хүсье<br>3. 2 жил тутам хийгдэж байх | 1. Санхүү ил тод, сумын албан хаагчдын ажлын ачааллыг харгалзан үзэх<br>2. Дутагдал гарч байгаа нь сайн гэхдээ давуу талыг гаргаж урам өгөх, санхүүгийн мэдээллээр сайн хангах,<br>3. Санхүүгийн хяналт шалгалт маш сайн, үнэтэй зөвлөгөөг өгч, эерэгээр заан зөвлөж тусалсан та бүхэнд баярлалаа<br>4. Хяналт шалгалтыг жил бүр хийж дутагдлыг илэрүүлж, заавар зөвлөмж өгч, ажил сайжирна.<br>5. 2022 оны 12 дугаар сард олон хүнд илүү цаг өгч тэр мөнгөө өөрсдөө нэхээд авсан. | | |